АХМАД НАСТНЫ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН АСУУДЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Ч.Онончимэг, А.Пагма, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

1. Ахмад настны асрамж, халамжийн асуудлаарх бусад орны туршлага ба Монгол Улсын статистик мэдээлэл
   1.1 Ахмад настны төрөлжсөн асрамж, халамжийн талаарх олон улсын туршлага
2. Ахмад настны халамж, асрамжийн талаарх Монгол Улсын статистик мэдээлэл
   2.1 Тэтгэвэр авдаг ахмадын тоо
   2.2 Ахмад настны нийгмийн халамж, үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө
   2.3 Тэтгэмж авдаг ахмадын тоо
   2.4 Ганц бие ахмадын тоо
   2.5 Хөнгөлөлттэй үнээр рашаан сувилалд хамрагдсан ахмадын тоо, хувь /5 жилээр/
   2.6 Асрамжийн газарт амьдардаг ахмадын тоо
   2.7 Орон сууцанд амьдардаг ахмад настны тоо, хувь

1. АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрууд дэлхийн олон оронд түгээмэл байгаа бөгөөд эдгээр асрамжийн газрууд нь асрамж шаардлагатай өндөр настнуудыг нийгмийн харилцаанд байлгах, бусад ахмад настнууд болон хамт олон дунд байх хэрэгцээг хангах, ая тухтай амьдрах орчныг бий болгох, шаардлагатай асрамж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Эдгээр төрөлжсөн асрамжийн газрууд нь цогцолбор хэлбэртэй, өмчлөлийн хувьд улсын, улс-хувийн хэвшлийн хамтарсан, хувийн зэрэг янз бүрийн харьяалал, санхүүгийн эх үүсвэртэй байна. Эдгээрээс сүүлийн үед түгээмэл бий болж байгаа асрамжийн газрын хэлбэрүүдийг авч үзье.

Ахмад настнуудад үзүүлэх асрамж, эмнэлгийн тусламж улс орон бүхэнд янз бүр байдаг бөгөөд хурдацтай хөгжиж байна. Өнөө үед нэг нутаг дэвсгэр дээр төвлөрсөн, ахмад настны өвөрмөц хэрэгцээ шаардлагад тохирсон, төрөлжсөн байгууллагуудын хөгжингүй тогтолцоо бүхий эрүүл мэнд-нийгмийн үйлчилгээний шинэ хэлбэр ихээхэн түгээмэл болжээ. Энэхүү шинэ хэлбэрийн байгууллагуудыг “Өндөр настны асрамжийн цогцолбор” (Eldercare residences) гэж нэрлэдэг ба энэ нь өндөр настны онцгой хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, үйлчилгээ бүхий оршин суух байрны цогцолбор юм.

Ийм хэлбэрийн цогцолбор нь тусдаа амьдрах сууц, ассистант тусламжийн сууц, урт хугацааны асрамжийн байр, өндөр настны асрамж, хоспис гэсэн хэд хэдэн янзын орон сууц, суурингаас бүрдэнэ.

Бусад орнуудад өндөр настны төрөлжсөн асрамжийн олон янзын хэлбэр байдаг бөгөөд дараах үндсэн хэлбэрүүдтэй. Үүнд:

- Гэр бүлийн асрамжийн газар (FCR)[283],
- Ассистант тусламжийн асрамж (ALF)[284],
- Өндөр настны асрамж (SNF)[285],

[283]Family Care Residences
[284]Assisted living Facility
[285]Skilled Nursing Facility

• Байнгын асрамжийн тэтгэвэрийн нийгэмлэг (CCRCs)[286] зэрэг болно.

Гэр бүлийн асрамжийн газар

Энэ төрлийн асрамж нь хоёроос зургаа хүртэл өндөр настан хамт амьдрах байртай, тусгай нийгмийн агентлаг, буяны байгууллагын мэргэжлийн ажилтан болон сайн дурынхан тэдэнд туслан гэр бүлийн уур амьсгал бүхий нөхцөлд тохитой амьдран, нөхөн сэргээх бүхий л талын туслалцаа, үйлчилгээг авах боломж бүрдсэн байдаг байна.

Ийм маягийн сууринд нэлээн олон тооны сууц байх ба соёл, худалдаа үйлчилгээний дэд бүтцийг мөн барьж байгуулсан байдаг бөгөөд чухамдаа энэ нь ахмад настнуудад зориулсан тусгай тосгон суурин хэлбэртэй байна.

Ийм сууринд амьдрах өндөр настнуудын асаргаа, үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэр улс орон бүрт өөр өөр байх боловч сүүлийн үед улсаас болон өндөр настнаас өөрөөс нь хамтран санхүүжүүлэх хэлбэр нэлээд зонхилж байгаа ажээ. Тухайлбал, Канадад ийм маягийн асрамжийн газруудыг Эрүүл мэнд, удаан хугацааны асрамжийн яамнаас санхүүжүүлдэг, Европ, Азийн зарим улсад нийгмийн даатгалын хөрөнгөөр байгуулдаг, АНУ-д зарим ийм асрамжийн газрыг ахмад настны эрүүл мэндийн даатгалын холбооны хөтөлбөрийн хөрөнгөөр, заримыг нь Америкийн тэтгэвэр авагчдын холбоотой (AARP) хамтарсан ашгийн бус буяны байгууллагуудаас санхүүжүүлдэг байна[287] .

Ассистант тусламжийн сайн дурын асрамж

Ийм төрлийн асрамжийн газар нь гэр бүлийн асрамжийн газар, өндөр настны асрамжийн газрын завсрын хэлбэр юм. Энд өндөр настнуудад өдөр тутмын амьдралд нь туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ эмч нарыг урьж авчиран үзлэг, эмчилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах, эмчилгээг хянах, бэлтгэгдсэн ажилтнууд тухайн хувь хүнд хандсан эмнэлгийн тусгай үйлчилгээ үзүүлэх, оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй, амар тайван аж төрөх бүхий л нөхцөлийг ханган ажиллахаар зохион байгуулагдсан байдаг.

Ассистант тусламжийн асрамжийн хэлбэр нь 1990-ээд оны үед бий болсон бөгөөд 24 цагийн турш эмнэлгийн тусламж авах шаардлагагүй боловч бүрэн бие даан амьдрах чадваргүй ахмадуудад зориулсан асрамжийн хэлбэр юм. Тус асрамжийн газар нь цөөн хүн амьдрах хэд хэдэн тусдаа орших байшин болон хэдэн зуун хүн амьдардаг том байшингаас нэгэн зэрэг бүрдэж болох боловч, энд үйлчлүүлэгч бүр гэртээ амьдарч байгаа мэт тусдаа тохилог өрөөтэй, ажилтнуудыг дуудах төхөөрөмжөөр тоноглогдож, өндөр настай хүмүүсийн амьдрах байрны стандартын дагуу баригдсан байдаг онцлогтой[288] . Хэдийгээр энд нэгдсэн гал тогоо, хоолны газартай, тогтмол хооллодог ч гэсэн, хэрэв настан хүсвэл өөрөө хоол ундаа бэлтгэх боломжоор бүрэн хангагдах ажээ.

Өндөр настны асрамжийн газар шиг өрөөнд нь эмнэлгийн хяналтын тоног төхөөрөмж суурилуулан, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтнууд байнга дэргэд нь ажиллахгүй боловч тусгай бэлтгэгдсэн нийгмийн ажилтнууд байнга ажиллан бусад шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг. Тэд угаах, арчих, цэвэрлэх, хоол хүргэх, хоол унд бэлтгэхэд нь туслах зэрэг ажлыг гүйцэтгэдэг.

Ийм сууринд угаалга, хими цэвэрлэгээний газар, гоо сайхны салон, дэлгүүр, кино театр болон бусад соёлын газрууд бий.

[286]Continuing Care Retirement Communities
[287]www.post-polio.org/net/confs.html
[288]A Guide for Assisted Living. Royal Institute of British Architects, 2011. www.architecture.com/Files/

АНУ-ын Ассистант тусламжийн Сууринги Холбооноос (ALFA) явуулсан судалгаанаас үзэхэд дээрх төрлийн асрамжийн газарт амьдарч байгаа хүмүүсийн дундаж нас 86,9 (эмэгтэйчүүдийн дундаж нас 87,3; эрэгтэйчүүдийн дундаж нас 85,7) байжээ. Энд амьдарч байгаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс 3 дахин их буюу 73,6 хувь нь байсан[289].

Ийм асрамжийн газарт амьдрах санхүүжилтийг нийгмийн даатгалын сан, улсын нийгмийн хамгааллын тусгай хөтөлбөр, буяны сангууд, үйлчүүлэгчдийн тэтгэвэр, төрөл төрөгсдийн хөрөнгө зэрэг хэд хэдэн эх үүсвэрээс хийж болдог ажээ.

Өндөр настны асрамж

Энэ төрлийн суурин нь өндөр настны асрамжийн газар ба тусгай сувиллын газруудын цогцолбор бөгөөд энд байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, биеийн болон оюун ухааны сааталтай хүмүүст үйлчилдэгээрээ онцлогтой.

Энэхүү газарт амьдран үйлчлүүлэгчид нь сувилагч, тэдгээрийн туслахуудын байнгын хяналтан дор байх ба нөхөн сэргээх мэргэжитнүүд тэдний бие, оюун ухаан, дадал, хэл ярианы чадварыг сэргээхэд тусладаг. Мөн байр, хоол, унаа, тээврийн хэрэгслээр хангадаг.

Энд өндөр мэргэжлийн сувилагчид гэхээс илүүтэйгэр бэлтгэгдсэн сувилагчийн туслахууд гол үүргийг гүйцэтгэдэг байна.

Ийм төрлийн асрамжийн газрын санхүүжилтийг улс орон бүрт янз бүрээр шийдвэрлэдэг. Тухайлбал, АНУ-д Medicare ба Medicaid гэсэн холбооны хөтөлбөрт хамруулан улсаас санхүүжүүлдэг. Их Британид орон нутгийн захиргааны төсвөөс тогтоосон хязгаарын хүрээнд санхүүжүүлдэг ба зардлын ихэнх хэсгийг үйлчлүүлэгч өөрөө хариуцдаг тул тухайн хүний төлбөрийн чадвараас ихээхэн хамаардаг байна.

Өнөө үед олон улс оронд улсын ийм асрамжийн газрыг аль болох эмнэлгийн бус харин гэр бүлийн уур амьсгалтай болгох, нийтийн палат бус олон жижиг өрөө, дундаа зочны болон гал тогооны өрөөтэй болгон өөрчилж байна. “Гэр бүл” болгон асаргаа хариуцсан ажилтантай, өөрсдийн дураар байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Дэлхийн олон оронд нийгмийн эх үүсвэрээс санхүүждэг улсын асрамжийн газраас гадна хувийн ийм төрлийн асрамжийн газрууд ихээхэн түгээмэл болсон ба энд үйлчлүүлэгч төлбөрийг өөрөө бүрэн хариуцдаг юм.

Байнгын асрамжийн тэтгэврийн нийгэмлэг

Асрамжийн энэ төрөл нь дээр дурдсан төрлүүдийг нэгтгэсэн хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, эдгээр асрамжийн хэлбэрүүд нэг дор, нэг цогцолборт оршиж үйл ажиллагаа явуулна. Жишээ нь АНУ-д ийм төрлийн дундаж асрамжийн газар нь 330 сууцны байртай ба үүнээс 231 нь гэр бүлийн, 34 нь ассистант тусламжийн сайн дурын асрамж, 70 нь өндөр настны асрамжийн байр байна.

Ийм маягийн цогцолбор нь ахмад, өндөр настны өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодог байна. Гэвч ийм төрлийн газар нь нэлээд өндөр үнэтэй, улсаас санхүүждэггүй, санхүүжилтийн гол эх үүсвэр нь буяны байгууллагын хандив, үйлчлүүлэгчдийн өөрсдийн тэтгэвэр, хадгаламж, бусад орлогоос бүрддэг байна.

[289]ALFA нь 1990 онд байгуулагдсан, төв нь Виржини мужийн Александр хотод байрладаг, АНУ-ын 34 мужид 4 төлөөлөгчийн газар, 30 салбартай. Тус Холбоо нь ийм төрлийн асрамжийн газар ажиллуулах зөвшөөрлийг олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг.

1.1 Ахмад настны төрөлжсөн асрамж, халамжийн талаарх олон улсын туршлага

АНУ:

1. Флорида дахь The Villages суурин. Амьдралын идэвхтэй ахмад настнуудын хэд хэдэн сууринаас бүрдэнэ. 2007 онд энд 75 мянган хүн амьдарч байжээ. Ихэнх байшингууд “55+” гэсэн загвартай, өөрөөр хэлбэл энэ сууринд үл хөдлөх хөрөнгийг зөвхөн 55-аас дээш насны хүмүүс худалдаж авах эрхтэй. Суурин нь Байнгын асрамжийн тэтгэврийн нийгэмлэг буюу CCRCs хэлбэртэй.

2. Өмнөд Калифорни дахь Cottesmore суурин. Эрүүл мэнд нь муудсан, эмнэлгийн тусламж шаардлагатай өндөр настнуудад зориулсан суурин. Хувийн байшингууд, өндөр настны асрамжийн газар, эрүүл мэндийн төв, ажилтнуудын орон сууц, зочид буудал, ресторантай. Тэтгэвэрт байдаг өвчтэй хүмүүст сахиур, асрагчаас эхлээд янз бүрийн мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээ хийх өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлдэг. Суурин нь Байнгын асрамжийн тэтгэвэрийн нийгэмлэг буюу CCRCs хэлбэртэй.

Их Британи:

Хартриг Оукс хэмээх суурин. Зөвхөн тэтгэвэрийн хүмүүс амьдардаг 152 байшинтай ба байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хүмүүс нь сувилагчийн хяналтан дор арай томхон байшинд шилжих боломжтой байдаг. Сууринд тухтай амьдрах бүхий л боломжоор хангагдсан байдаг бөгөөд суугчид нь тусгай татвар төлдөг, шинэ оршин суугчид нэмэгдэхийн хэрээр хөрөнгө нь мөн нэмэгддэг. Суурин нь Ассистант тусламжийн асрамж буюу ALF хэлбэртэй.

Австрали:

Eldercare сууринги йн сүлжээ. Эдгээр суурин нь улсын санхүүжилт болон оршин суугчдын төлбөрийн мөнгөөр санхүүжнэ. Үндсэн хэлбэр нь Гэр бүлийн асрамжийн газар (FCR), Ассистант тусламжийн асрамж (ALF)-ийн хосолсон хэлбэртэй.

Испани:

Барселонд онцгой асаргаа шаардлагатай боловч төлбөрийн чадваргүй өндөр настнуудад зориулсан, улсын төсвөөс санхүүждэг, 24 байшин бүхий төрөлжсөн асрамжийн газар ажилладаг. Өндөр настны асрамж (SNF) хэлбэртэй.

2. АХМАД НАСТНЫ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2.1 Тэтгэвэр авдаг ахмадын тоо */мянган хүн/*

№		2010 он	2011 он	2012 он	2013 он
1	Өндөр насны тэтгэвэр	218.8	219.6	224.7	230.3
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	70.0	67.0	65.8	64.5
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	35.1	32.1	29.9	27.4
4	Цэргийн тэтгэвэр	13.6	13.6	14.2	14.7
	Нийт	**337.5**	**332.3**	**334.6**	**336.9**

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2013 он.

2013 оны байдлаар нийт 336,9 мянган хүн тэтгэвэр авч байгаагаас 68,3 хувь буюу 230,3 мянган иргэд өндөр насны тэтгэвэр, 19,1 хувь буюу 64,5 мянган иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 8,1 хувь буюу 27,4 мянган иргэн тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4,4 хувийг буюу 14,7 мянган иргэд цэргийн тэтгэвэр тус тус авч байна.

Олгосон тэтгэврийн хэмжээ */сая төгрөгөөр/*

№		*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
1	Өндөр насны тэтгэвэр	265 643.3	328 724.0	516 542.0	593 268.5
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	59 255.6	70 211.0	111 798.7	124 946.0
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	27 378.6	30 677.6	47 147.6	50 364.2
4	Цэргийн тэтгэвэр	22 755.2	28 593.4	58 642.3	68 907.6
	Нийт	**375 032.7**	**458 206.0**	**734 130.6**	**837 486.3**

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2013 он.

2013 онд өндөр насны тэтгэвэрт 593 268.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 124 946.0 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 50 364.2 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 68 907.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2013 онд олгосон тэтгэврийн нийт хэмжээ өмнөх оноос 14,1 хувиар өссөн бол 2010 онтой харьцуулж үзэхэд 123,3 хувиар буюу 2,2 дахин өссөн байна.

2.2 Ахмад настанд үзүүлдэг нийгмийн халамж үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө */сая төгрөгөөр/*

	2009 он	*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө /тусламж,хөнгөлөлт/	6508.3	8401.1	9576.5	11262.9	14252.7

Эх сурвалж: НХҮЕГ

Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд 2011 онд 9576,5 сая төгрөг, 2012 онд 11262,9 сая төгрөг, 2013 онд 14252,7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Ахмад настанд үзүүлдэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо */мянган хүн/*

Халамжийн үйлчилгээний төрөл	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	160.5	292.5	407.4	372.9	396.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ	15.2	17.6	42.9	21.9	24.1
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт	107.9	108.2	118.7	112.1	126
Алдар цолтой ахмадад үзүүлсэн тусламж	-	125.6	204.3	205	202.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт	37.4	35.9	36.5	29.8	38.7

Эх сурвалж: www.1212.mn

2.3 ба 2.4 Тэтгэмж авдаг ахмадын тоо /ганц бие ахмад настны тоо/

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд /тусламж хөнгөлөлт/ 2009 онд 107 842, 2010 онд 108158, 2011 онд 118 672, 2012 онд 112 103, 2013 онд 125 941 ахмад настан хамрагдсан байна. Мөн ганц бие ахмад настны тоог тэднийг асарч байгаа иргэдэд олгосон асаргааны тэтгэмж авсан хүний тоогоор авсан болно.

	2009 он	*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
Тэтгэмж авдаг ахмад настны тоо /ганц бие ахмад настныг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмж/	13 235	16 068	15 009	14 676	16 800

Эх сурвалж: НХҮЕГ

2.5 Хөнгөлттэй үнээр рашаан сувилалд хамрагдсан ахмадын тоо, хувь, 5 жилээр

	2009 он	*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
Хөнгөлөлттэй үнээр рашаан сувилалд хамрагдсан ахмад настны тоо	7 919	12 144	13 586	14 585	18 069

Эх сурвалж: НХҮЕГ

Дээрх хүснэгтэд харуулснаар сүүлийн 5 жилд хөнгөлөлттэй үнээр рашаан сувилалд хамрагдсан ахмадын тоо эрс өсч, 2013 онд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлсэн ахмадын тоог 2009 онтой харьцуулахад 2,3 дахин буюу 128,2 хувиар өсч 2013 онд нийт 18069 ахмад настан үйлчлүүлсэн байна.

2.6 Асрамжийн газарт амьдардаг ахмадын тоо

	2009 он	*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
Асрамжийн газарт амьдардаг ахмад настны тоо	-	-	327	312	335

Эх сурвалж: НХҮЕГ

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр асрамжийн газарт амьдардаг ахмад настны тоо 2011 онд 327, 2012 онд 312 байсан бол 2013 онд 335 болж, өмнөх жилээс 7,3 хувиар өссөн байна.

2.7 Орон сууцанд амьдардаг ахмад настны тоо, хувь

		2013 он
Өөрийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй ахмад настны тоо	2013 онд хийгдсэн Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаж, Салбар дундын мэдээллийн нэгдсэн санд оруулсан өрхийн мэдээллээс...	44 264

Эх сурвалж: НХҮЕГ

2013 онд хийгдсэн Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсан мэдээллээс өөрийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй ахмад настны тоо 44264 байна.